

Англи хэлний хэрэглээний тархалт

Намсрайжавын Мөнхбаяр 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Англи хэлний тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол Улс

Хүлээн авсан - Received:
2024-10-24

Засварласан - Revised:
2024-11-29

Хэвлэгдсэн - Published:
2024-12-30

munkhbayar@msue.edu.mn

ORCID: [0009-0007-4457-6561](https://orcid.org/0009-0007-4457-6561)



© 2024, Author(s)

Хураангуй:

Англи хэл дэлхийн хэл болсон төдийгүй англи хэл нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөө нийгмийн салбарт гүйцэтгэх үүргийг судлахын тулд англи хэлний хэрэглээг судлах нь зайлшгүй юм. Энэхүү судалгааны ажлын зорилго нь англи хэлний хэрэглээ буюу англи хэл нийгмийн салбарт ямар үүрэг гүйцэтгэж байгаа болон дэлхийн улс орнуудад хэрхэн хэрэглэгдэж байгааг судлахад оршино. Тус судалгааны ажилдаа чанарын судалгааны аргууд болох социологийн судалгаа, асуулга, ажиглалт, хэвлэл мэдээллийн бааз суурь бүхий томоохон сэтгүүлүүд болон бусад эх сурвалжаас авсан материалд анализ хийж нэгтгэн дүгнэх, жишин харьцуулах логикийн аргууд зэргийг ашиглав. Эцэст нь дүгнэн хэлэхэд англи хэлийг заах аргазүйн хувьд ерөнхий ба мэргэжлийн англи хэл, боловсролын салбарт хэрэглэгдэж буй зориулалтаар нь англи хэлийг үндэсний хэлний үүргээр хэрэглэж буй орон, англи хэлийн хоёрдогч хэлний зориулалтаар хэрэглэж буй орон, англи хэлийг олон улсын хэлний зориулалтаар хэрэглэж буй орон гэж ангилдаг байхад англи хэлийг дэлхийн улс орнуудад хэрэглэгдэж

буй байдлаар нь англи хэл үндэсний хэл болсон орон, англи хэлийг өдөр тутмын албан ёсны хэлний үүргээр хэрэглэгдэг орнууд, англи хэлийг олон улсын хэлний зориулалтаар үзэж судалдаг орнууд гэх зэргээр ангилдаг байна. Ийнхүү англи хэлний хэрэглэгдэх үүрэг зориулалт болон хэрэглээ, нийгмийн салбарт гүйцэтгэх үүрэг цаашид өсөх хандлагатай байна.

Түлхүүр үгс: Англи хэл, төлөвлөлт, үүрэг, нийгмийн салбар, англи хэлний ирээдүй

ОРШИЛ


Англи хэлний нийгэмд эзлэх байр суурь ба нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөг судлах нь сонирхолтой бөгөөд өргөн хүрээтэй сэдэв юм. Англи хэлний нийгмийн байр суурийг судлахын зэрэгцээ англи хэл боловсролын салбарт хэрхэн нөлөөлж, ямар үүрэг гүйцэтгэж байгаа болон англи хэлний эдийн засагт үзүүлэх нөлөө, англи хэл ба соёлын нөлөөг судлах нь чухал ач холбогдолтой билээ. Тус өгүүлэлдээ 1. Англи хэл дэлхийн улс орнуудад хэрхэн хэрэглэгдэж байна вэ? 2. Өнөөдөр ямар салбаруудад англи хэл хамгийн их хэрэглэгдэж байна вэ? 3. Англи хэл нь олон улсад ямар

байдлаар соёл, эдийн засаг, улс төрийн харилцаанд нөлөөлж байна вэ? гэсэн асуултаудын хүрээнд судалгаа хийсэн байдлаа хамруулан авч үзэхийг зорилоо.

Судалгааны үр дүн:

Англи хэлний боловсролын бодлогыг олон улсын хэмжээнд 3 үндсэн хэсэгт хуваан авч үзсэн байдлыг хүснэгтээр харуулав.

Схем 1. Англи хэлний үүрэг зориулалт ба ангилал



Англи хэл үндэсний хэл болсон орнуудад Английн вант улс, Америкийн нэгдсэн улс, Австрали, Ирланд, Шинэ Зеланд, Канад зэрэг 6 орнуудыг багтаан үздэг. Дэлхийн хэмжээний англи хэлийг заах онол (ELT), заах арга зүйн аргууд, хичээл заах материал, багш нарыг бодлоготойгоор бэлтгэж санал болгодог. Тэдний англи хэлийг заах (ELT) бодлого нь суралцагсдыг англиар ярьдаг нийгэм, соёлд нэгтгэх зорилготой байсан бол одоо олон хэлт соёлын зүгт чиглэж суралцагсдын эх хэл болон соёлын өвийг хадгалан авч үлдэх бодлогыг баримтлах болсон байна. Дээрх 6 орноос гадна Өмнөд Африкт 4.8 сая, Нигерт 4 сая, Сингапурт 1 сая унаган англи хэлтэй хүмүүс амьдарч, дэлхийд англи хэл 527 сая хүн үндэсний хэл болсон байна (W.Tollefson, Language Policies in Education, 2012, p. 13) *Англи хэлийг өдөр тутмын албан ёсны хэлний үүргээр хэрэглэдэг* эдгээр орнуудад Энэтхэг, Малайз, Сингапур зэрэг улсуудыг хамруулж болох ба бүгд олон үндэстний, олон хэлний соёлыг баримтлагч улсууд юм. Англи хэл дээрх улсуудын нийгэмд нэвтрэх үйл явцын дунд Энэтхэгийн англи хэл, Малайзын англи хэл, Сингапурын англи хэл гэх зэргээр англи хэлний хувилбарууд гарч ирсэн ба бүгд өөрийн гэсэн хэлбэр болон хэрэглээний хэм хэмжээтэй болжээ. Англи хэлийг хоёрдогч гадаад хэлээ болгон үздэг улс орнуудын англи хэлийг заах бодлогын хувьд англи хэлийг олон соёлт нийгмийн үзэл бодлоо илэрхийлэх арга хэрэгсэл, англи хэлээр дамжуулан олон соёлыг дэлгэрүүлэх бодлогыг баримтлах болсон байна.

Англи хэлийг олон улсын хэлний зориулалтаар ашигладаг, заадаг, сурдаг орнуудыг урьд нь англи хэлийг гадаад хэлний зориулалтаар эзэмшдэг улс (EFL) гэж нэрлэдэг байсан. Эдгээр орнуудын ихэнх нь англи хэлийг олон улсын харилцааны хэл, олон улсын соёлын ойлголцлын хэл гэдгийг таньж мэдсэн учраас онцлон үздэг. Англи хэлийг олон улсын харилцааны хэл хэмээн үздэг орнуудад Европын холбооны улс, Турк, Тайланд, Иран, Хятад, Солонгос, Бразил зэрэг орнуудыг багтаан оруулдаг байна.

Англи хэл нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, нийгэм, эдийн засгийн хэл болж дэлхий дээр англиар ярьдаг 1.8 тэрбум хүн, англи хэл үндэсний хэл болсон 527 сая, хоёрдогч гадаад хэл болгон судалж буй 850 сая, 100 гаруй оронд хувийн болон албан секторт англи хэл хэрэглэгддэг, Зүүн Өмнөд Азийн 10 орон, түүнчлэн Хятад, Япон, Солонгосыг оролцуулаад англи хэлээр ярьдаг 450 сая хүн,

Европчуудын 38% нь англи хэлээр ярьдаг, НҮБ-ийн 126 орны 95% нь албан хэргийн баримт бичгүүдээ англи хэл дээр хүлээн авдаг, олон улсын байгууллагын 85% нь англи хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг, дэлхийн 80 гаруй оронд тусгай статусаар судлагдаж байгаа зэргээс үзэхэд англи хэл дэлхийн нийтийн *глобал* хэл болсон (Friedman, 2014). 2050 он гэхэд дэлхийн хүн амын бараг хагас хувь буюу 3 тэрбум хүн англи хэлийг ямар нэг хэмжээгээр эзэмшсэн байна гэсэн тооцоо байгаа ажээ (wikipedia.org, n.d.).

Зураг 1. Глобал англи хэлний хэрэглээ



Англи хэл шинжлэх ухааны салбарт 2012 онд дэлхийн хамгийн том мэдээллийн суурь бааз бүхий сэтгүүл “SCOPUS”-д мэдээлснээр 239 орны 21000 эрдэм шинжилгээ, судалгааны өгүүллийн 80% нь англи хэлээр бичигдсэн, шинжлэх ухаан техникийн сэтгүүлийн 50% англи хэлээр хэвлэгддэг, хэл шинжлэлийн салбарт хэвлэн нийтлэгдсэн нийт өгүүллийн 90% нь англи хэл дээр бичигддэг. Герман, Франц, Испани зэрэг орнуудад эрдэм шинжилгээний өгүүлүүдийг англи хэл дээр бичих байдал нь өөрийн орны хэл дээр бичих хэмжээнээс хэд дахин их болов. Тухайлбал, Нидерландад энэ харьцаа 40:1 байжээ. Ихээхэн хэмжээний эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргадаг 8 орны сэтгүүлд судалгаа хийж үзэхэд англи хэлээр бичих харьцаа өсөх хандлагатай байна. Эрдэмтдийн 3/2 англи хэл дээр судалгаа хийдэг ба тус хэл шинжлэх ухааны хэл болсон нь шинэ мэдээллүүдийг олж авах боломжийг олгож, аль ч улс оронд бие биетэйгээ харилцах болсон төдийгүй олон эрдэмтэд англи хэлийг сурах хүсэл тэмүүлэлтэй байсаар байгааг судлаачид тэмдэглэж байна.

Бангладеш, Камбож, Хятад, Индонез, Япон, БНСУ, Тайланд зэрэг улсын дээд сургуулиудад англи хэлийг өндөр түвшинд үздэг, “шинжлэх ухааных нь хэл” болсон тул хүн амынх нь тодорхой хэсэг англи хэлийг харилцааны хэрэгслийнх нь хувьд зохих хэмжээнд мэдэж, олон улсын харилцаанд энэ хэлийг өндөр түвшинд ашигладаг орнууд юм.

Англи хэл бизнесийн салбарт дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30-40% англи хэл дээр тооцоологддог, цахим харилцааны 80% буюу 5/4 тус хэлээр явагдаж байгаа зэргээс тодорхой

харагддаг. Олон үндэстний бизнесийн компаниуд болох Самсунг, Нокиа, Майкрософт, Техникolor, Ренолт зэрэгт бизнесийн үйл ажиллагаагаа явуулах хэл нь газарзүйн бүс нутгийн байршил үл харгалзан англи хэл болсон. 2010 онд Хироши Микитани, Ракутен зэрэг Японы томоохон онлайн худалдааны бизнесийн албан ёсны хэл нь англи хэл байна гэсэн шийдвэр гарсны үр дүнд 7100 ажилтаны 25% нь англи хэлтэй болсон зэргээр тус хэлний бизнест үзүүлэх нөлөө их байгаа нь харагдлаа (W.Tollefson, Language Policies in Education, 2012, p. 13).

Эдийн засаг, технологийн салбарт татварын таатай бодлого, дэд бүтцийн өндөр хөгжил, ажиллах хүчний боловсрол, англиар ярих чадвар зэрэг нь хувьцаа эзэмшигчидийн сонирхолыг төрүүлж, корпорациудын сэтгэлийг татах замаар тухайн компани хөл дээрээ бат зогсох суурийг тавьж өгдөг. Ийнхүү англи хэл хөдөлмөрийн зах зээлд нөлөөлдөг болох нь харагдаж байна. Хоёрдогч гадаад хэл, гуравдагч гадаад хэл байхаас үл хамааран англи хэлний өндөр чадварийг шаардсан олон төрлийн ажил мэргэжил бий болж үүнийг эзэмшсэн тохиолдолд дэлхийн эдийн засгийн тодорхой салбарт ажлын байраар хангагдах, ажил мэргэжилдээ ахиц дэвшил гаргах боломжоор хангагдана, өрсөлдөх чадвар бий болно. (Starfield, 2014) Дэлхийн хэмжээнд 3 тэрбум ажиллах хүчний 7% буюу 200 сая нь 53000 олон улсын корпораци, түүнд хамаарах нэгж байгууллагад ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 40%-ийг, худалдааны гуравны хоёрыг бүрдүүлж байдаг. Эдгээр компаниудад байршил үл харгалзан лингва франка хэл, англи хэл түгээмэл хэрэглэгддэг. (Jenkins, English as a Lingua Franca in the International University, 2009) Германы худалдаа аж үйлдвэрийн танхим 64 оронтой худалдааны үйл хэргийг хөтлөн явуулахдаа дан ганц англи хэлийг харилцааны хэл болгон ашигладаг зэргээр англи хэлний эдийн засгийн салбарт жинтэй хувь нэмэр оруулж байна.

Улс төрийн онол судлаач Ван Париж “Англи хэл лингва франка хэл болсоны ачаар дэлхийн нийгэм, эдийн засгийн тэгш эрхийг хангахад дөхөм болсон, учир нь бага орлоготой орнуудад англи хэлийг зааж сургах болж өндөр боловсролтой, англиар ярьдаг иргэдийг эдийн засгийн өндөр мэдлэг бүхий баян орнууд руу шилжин суурьших тоо багассан” гэж үзсэн. Тэрбээр орлогын алдагдлыг бууруулж, корпорацийн татварыг нэмэгдүүлэх замаар англи хэлний сургалтад хөрөнгө оруулалт хийвэл дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт дээшилнэ гэж тодорхойлсон. (W.Tollefson, Language Policies in Education, 2013)

Дэлхийн лингва франка хэл нь олон улсын харилцааг бэхжүүлэх, эдийн засгийн тэгш эрхээр хангах, хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг бүрдүүлэх, үндэстэн хоорондын зөрүүтэй байдлыг үгүй болгоход зайлшгүй шаардлагатай байдаг зэргээс үзэхэд англи хэлний дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө их байна.

Англи хэл боловсролын салбарт гүйцэтгэх үүргийн хувьд дэлхийн 60 оронд сургалтын хэл болсон, 2008 оны байдлаар олон улсын оюутнуудын 50-70% англи хэл үндэсний хэл болсон орнуудад суралцаж байна. Тухайлбал, олон улсын эдийн засаг, хамтын хөгжлийн газрын мэдээлснээр 2008 онд АНУ 18.7%, Англи 10%, Австрали 6.9,% бусад Герман 7.3%, Франц 7.3% байгаа нь англи хэл сургалтын хэл болоод байгааг харуулж байна. 2008 оны байдлаар олон улсын оюутнуудын 43% нь англи хэл үндэсний хэл болсон орнуудад суралцаж байна. 2010 оны байдлаар Хятад улсын бага сургуульд 120 сая сурагч суралцсан ажээ (Jenkins, English as a Lingua Franca in the international University, 2014, p. 2).

Англи хэлний соёлын салбарт оруулах үүргийн хувьд дэлхийн хамгийн том 7 телевизийн нэвтрүүлэг англи хэл дээр явагддаг (CBS, NBC, ABC, BBC, CBC, CNN, C-Span), дэлхийн нийт номны гуравны нэг, сонин хэвлэлийн 50% англи хэл дээр хэвлэгддэг, шилдэг 50 сэтгүүл англи хэл дээр бичигддэг, киноны зах зээлийн 85% англи хэл дээр, дэлхийн улс орнуудын 30 орчим хувь нь өөр хоорондоо

англи хэлээр харилцдаг нь англи хэлний соёлын салбарт үзүүлэх нөлөөг харуулж байна (Cheshire.J, 2008, р. 105).

Англи хэл боловсрол, соёл, шинжлэх ухаан, бизнесийн салбарт чухал үүрэг гүйцэтгэж нийгмийн хөгжилд нөлөө үзүүлэхийн сацуу англи хэл дэлхий нийтийн харилцааны *лингва франка* болсон. Кембриджийн англи хэлний толь бичигт тайлбарласнаар лингва франка гэдгийг өөр хэлээр ярьдаг хүмүүсийн ойлголцлын хэл, гүүр болсон хэл, түгээмэл хэл, худалдааны хэл гэж ойлгож болно. Уг үгийн гарвал зүйг судалж үзэхэд Лингва гэдэг нь Португали болон Италиар “хэл” гэсэн утгатай, франка гэдэг нь Грекийн *Phrankoi*, Арабаар *Faranji* гэж орчуулагддаг ба “тодорхой” гэсэн утгатай, Баруун Европод анх хэрэглэгдэж эхэлсэн байна. Англи хэл лингва франка (ELF-English as a Lingua Franca) болохын хувьд дэлхийд хамгийн өргөн хэрэглэгддэг орчин үеийн хэл, төрөлх хэл нь өөр хүмүүс болон унаган англи хэлээр ярьдаг хүмүүсийн харилцааны хэл болсон гэдэгтэй хамааруулж үздэг.

Англи хэлийг сургалтын хэл болгох хандлага улс орнуудад глобаль шинжтэй болж байна. Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгаанаас харахад зөвхөн Ази, Номхон далайн сав газрын 24 орны 25% гэхэд англи хэлийг төрийн албан ёсны хэл болгосон улсууд байна. Австрали, Күүкийн арлууд, Фижи, Филиппин, Энэтхэг, Шинэ Зеланд зэрэг орон англи хэлийг төрийн албан ёсны хэл болгосон төдийгүй эдгээр орны бүх шатны сургуулиудад сургалтыг англи хэлээр явуулдаг байна. Англи хэл сургалтын хэл болсон олон улсын их, дээд сургуулиудын оюутнуудын хувьд Германы англи хэл (Denglisch), Хятадын англи хэл (Chinglish), Сингапурын англи хэл (Singlish) зэрэг англи хэлний шинэ хувилбарууд үүсээд байгаа ба дэлхий дахины ярианы англи хэлний стандарт хувилбар (WSSE-World Standard Spoken English)-ыг баримтлах нь зүйтэй гэж үзэх болсон. Энэ нь нутгийн аялгууны нөлөөлөлд автсан унаган англи хүмүүст ч гэсэн хамаатай байна.

Малайзын холбоо, Баруун Самоа, Малдивийн арлууд, Папуа Шинэ Гвиней, Сингапур, Шри Ланка зэрэг улс орон англи хэлийг албан ёсны хэл болгож тунхаглаагүй ч түүнийг өдөр тутмынхаа харилцааны хэрэглүүр болгосон төдийгүй эдгээр орны бүх шатны сургуулиудад сургалтыг англи хэлээр явуулдаг байна.

Судалгаанаас үзэхэд Азийн Япон, БНСУ, БНСВУ, түүнээс гадна Баруун Ази, арабын ертөнц тэр чигээрээ өөрийн үндэсний хэл, бичгийн зэрэгцээ англи хэлийг албан ёсны олон улсын харилцааныхаа хэл бичиг болгож авсан байна.

Олон улсын их, дээд сургуулиудын оюутнуудын шилжилт хөдөлгөөн ихсэх хандлагатай байгаа нь эдийн засаг хамтын ажиллагааны нийгэмлэг (OECD)-ийн статистик тоон үзүүлэлтээс харагдаж байна. 2005 оны байдлаар Хятад улс 179 орны 141,000 оюутныг хүлээн авсан бол 2008 онд дэлхийн хэмжээнд их, дээд сургуульд суралцагч оюутнуудын 50 гаруй хувь нь англи хэлтэй орнууд болох АНУ, Англи, Австрали, Канад, Шинэ Зеланд зэрэг улсуудад, мөн Франц, Герман улсад суралцаж, тэдний сургалтад англи хэл голлох хэл болсон байна. Барууны орнуудад суралцах Азийн оюутнууд нэмэгдэхийн хирээр Хятад 13%, Энэтхэг 5.7%, Солонгос 3.7%, Япон 2.4% улсууд ихэнх хувийг эзэлж байна. Ази Номхон далайн бүс нутагт суралцах гадаад оюутнуудын тоо өсч тэдний 4% нь Япон улсад байна. Энэхүү дэлхийн дээд боловсролын системийн олон улсжих үйл ажиллагаанд академик лингва франка хэл (ELFA-English as a lingua franca in Academic settings) чухал үүрэг гүйцэтгэдэг.

Нийгмийн хөгжилд дэлхийн хэлнүүд ямар хэмжээнд байгаад үнэлгээ тогтоодог гол байгууллагууд нь ЮНЕСКО-гийн статистикийн байгууллага, судалгаа шинжилгээний баг, НҮБ-ийн олон улсын нийгэм, эдийн засгийн хэрэг эрхлэх газар, дэлхийн эдийн засаг, хамтын хөгжлийн байгууллага

(OCED) зэрэг юм. Эдгээр байгууллагуудын судалгааг харахад интернет хэрэглэдэг хүний тоогоор англи хэл нэгдүгээрт буюу 452 сая хүн, тус хэлийг хэрэглэдэг орны тоогоор нэгдүгээрт буюу 101 улсад, англиар ярьдаг хүнийхээ тоогоор хоёрдугаарт, өргөн тархсан байдлаараа гуравдугаарт гэх зэргээр англи хэлний эзлэх байр суурь дэлхийн нийтийн хэмжээнд өндөр байсаар байна.

Англи хэл нийгмийн харилцааны статус хэрэглэгдэх үүрэг, цар хүрээгээр үндэстний хэл (national language), улсын хэл (state language), албан ёсны хэл (official language), бүс нутгийн хэл (regional language), харилцааны нийтлэг хэл (communicative language) гэх мэт улс орнуудад өндөр статустай байна.

Үндэсний хэл гэдэг нь үндэстэний харилцааны хэрэгсэл /бичгийн ба аман хэлбэрээр орших/ нийгэм-түүхийн категори бөгөөд тухайн улс болон үндэстнийг тодорхойлох хэл /хэлний төрөл, аялгуу/ юм. Албан ёсны хэл гэдэг ойлголт нь улс орнууд колончлолоос чөлөөлөгдөж шинэ үндэстэн бий болсонтой холбоотойгоор гарч ирсэн ба олон үндэстэн, олон хэлтэй улсуудад төрөөс явуулах үйл ажиллагаа нийтэд ойлгомжтой, нийтлэг байлгах зорилгоор аль нэг хэлийг албан ёсны болгон хуульчилдаг байна.

Англи хэлийг төрийн үйл хэрэгтээ хэрэглэж, хуулиа уг хэлээр гарган, албан ёсны хэлээ болгосон 400 сая гаруй хүн байна, англи хэл үндэсний хэл болсон 6 улс, албан ёсны хэл болсон 35 улс, мөн тус хэл бүс нутгийн хэл болсон. Энэ талаархи статус судалгааг хүснэгт 1.2-г харуулав (Zegiimaа.Ch, 2012).

Хүснэгт 1. Англи хэл үндэсний хэл ба албан албан ёсны хэл болсон орнууд

Англи хэл үндэсний хэл болсон орнууд		
<ul style="list-style-type: none"> ○ 6 оронд үндэсний хэл болсон нь : ○ Америкт 231 сая хүмүүс ○ Англид 60 сая хүмүүс ○ Канадад 19 сая хүмүүс 	<ul style="list-style-type: none"> ○ Австралид 17 сая хүмүүс ○ Ирландад 4.2 сая хүмүүс ○ Шинэ Зеландад 3.7 сая хүмүүс <p>Үүнээс гадна дараах орнуудад:</p>	<ul style="list-style-type: none"> ○ Өмнөд Африкт 4.8 сая, ○ Нигерт 4 сая ○ Сингапурт 1 сая хүн унаган англи хэлтэй байна.
Англи хэл албан ёсны хэл болсон орнууд		
<ul style="list-style-type: none"> • Америк тивд:-Антигуа Барбуда, Барбадос, Белиз, Доминик, Гренад, Гуана, Ямайка, Сайнт Китс Невис, Сант Люсиа, Сант Винсинт Гренад, Тринадад Тобаго. • Европт: Ирланд, Малта, Англи улс. 	<ul style="list-style-type: none"> • Африкт: Ботсвана, Камерун, Этиоп, Эритрий, Гамбиа, Гана, Кения, Лосото, Либериа, Малави, Моритус, 	<p>Азид:</p> <ul style="list-style-type: none"> • Энэтхэг, • Пакистан, • Филиппин, • Сингапур улс.

<ul style="list-style-type: none">• Австралид: Фижи, Кирибати, Маршалын арлууд, Микронесийн Холбооны Улс, Шинэ Зеланд, Шинэ Гвиней, Самао, Соломоны арлууд, Тонга, Тувалу, Вануату улс.	<ul style="list-style-type: none">• Өмнөд Африк: Өмнөд Судан, Судан, Свазиланд, Танзани, Уганда, Замбиа, Зимбаб улс.	
---	---	--

Дүгнэлт

Монгол улс олон тулгуурт гадаад бодлого баримтлах болсон, дэлхий нийтийн ирэх 15 жилийн хөгжлийн хөтөлбөр болох Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд нийцэх үүднээс хөгжин дэвших, хүчирхэг улсыг байгуулах, ажилд орох боломжоор хангагдах, ядуурлаас гарах, гадаад хэлний боловсрол эзэмшүүлэх, англи хэлийг мэргэжлийн өндөр түвшинд эзэмшсэн, хөрвөх чадвартай боловсон хүчин бэлтгэх онцгой үүрэг гарч ирсэн билээ. Үүнтэй холбогдуулан англи хэлний ач холбогдол, үүрэг өөрчлөгдөн боловсрол, соёл, шинжлэх ухаан, бизнес, эдийн засагийн салбарт англи хэлний гүйцэтгэх үүрэг давамгайлж байна.

Өнөөдөр англи хэл олон улсын харилцааны нийтлэг хэл буюу лингвофранкийн үүргийг гүйцэтгэх болсон бөгөөд судлаачид англи хэл дэлхийн улсуудын нийгмийн харилцаанд гүйцэтгэх үүрэг, цар хүрээндээ шалтгаалан дотоод тойрог (the Inner Circle) /англи хэл төрөлх хэлний статустай, гадаад тойрог/ (the Outer Circle) /англи хэл албан ёсны статустай 50 гаруй улс/, өргөжсөн тойрог (the Expanding Circle) /англи хэл гадаад хэлний статустай/ гэж хувааж байгаа ба Монгол улс сүүлийн тойрогт буюу англи хэлийг сурч судладаг, хоёрдогч хэлээ болгон үздэг улсын бүлэгт хамаарагдаж байгаа юм.

Англи хэл олон төрөл ангилалтай байгаа ба түүнийг *оригинал англи* (Original English) британий англи хэл; *англи хэлний шинэ хувилбар* (New Englishes) хойт америк, австрали, өмнөд африкийн англи хэл; *шинэ шинэ англи хэлний хувилбар* (New New Englishes), англи хэлийг үзэж буй улс орнуудын аялга орсоноос хамаарч сингапурын англи (Singlish), хятадын (Chinglish), Arablish, Benglish, Deutschlish, Dutchlish, Franglais, Hindlish, Indonglish, Italghish, Japlish, Korlish, Russlish, Spanglish, Swedish англи хэл бий болсон гэж хувааж үзэж байна. Түүнчлэн, төрөлх англи (native English) олонхийн хэрэглээний англи (majority English), харилцааны хүрээндээ шалтгаалан боловсрол, соёл, шинжлэх ухаан, бизнес, эдийн засгийн салбарын гэх зэрэгээр ангилж байгаа төдийгүй англи хэлний статус өндөр хэвээр байж нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүрэг ирэх 500 жилд хэвээр хадгалагдан үлдэнэ гэж хэл судлаачид үзсэн байна.

Spread of English usage

Munkhbayar Namsraijav 

Ph.D, English Language Department, Mongolian National University of Education,
Ulaanbaatar, Mongolia

Abstract

Not only English has become a global language, but it is also essential to study the use of English in order to study its impact on social development and its role in society. Within this study we used qualitative studies such as sociological study, questionnaires' observation, have done analyses and summarized materials taken from magazines and other sources with a large media base and logical methods of comparison. In conclusion English is divided as general English and ESP for teaching method, for educational purposes it is divided as ENL-English for national language, ESL-English for second language, EIL- English as an international language. As English is being studied with special status more than 80 countries of the world it has become global language and it is estimated that by 2050, almost half of the world's population, or 3 billion people will have mastered English to some degree. From here we can conclude that English status has been high in all field of the society and it has been showing high influence on the future development of the society.

Keywords: *English, planning, role, social sector, future of English*

Ном Зүү

Cheshire.J. (2008). *English around the world*.

Jenkins, J. (2009). *English as a Lingua Franca in the International University*. London and New York: Routledge.

Jenkins, J. (2014). *English as a Lingua Franca in the International University*. New York: Routledge.

Starfield, B. P. (2014). *The Handbook of English for Specific Purposes*. UK: UK Printing.

W.Tollefson, J. (2012). *Language Policies in Education*. Retrieved from <https://www.scribd.com/document/464041515/language-policies-in-education-2012>

W.Tollefson, J. (2013). *Language Policies in Education*. USA: Routledge.

Zegiimaa.Ch, C. b. (Хян.). (2012). *Language policy and planning of Mongolia*. UB. printing.